




“МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ”

2016-2019 ОНЫ ТАНИЛЦУУЛГА



www.nso.mn

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ.....	1
ХҮН АМ, НИЙГМИЙН БАЙДАЛ.....	4
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ.....	26

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АХОТ	Ажиллах хүчний оролцооны түвшин
АҮ	Аж үйлдвэр
БНАСАУ	Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс
БНСВУ	Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ГЕГ	Гаалийн Ерөнхий Газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЗГ	Засгийн газар
МБ	Монгол банк
МИК	Монголын ипотекийн корпорац
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
ОХУ	Оросын Холбооны Улс
СБР	Статистикийн бизнес регистр
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
ҮНО	Үндэсний нийт орлого
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ХАА	Хөдөө аж ахуй
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

ТЭМДЭГЛЭГЭЭ

* Урьдчилсан гүйцэтгэл

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016	2019*	$\frac{2019}{2016}$ %
Монгол Улсын хүн ам, оны эцэст	мян.хүн	3 063.6	3 193.8	104.2
1000 хүнд ногдох ердийн цэвэр өсөлт		20.1	18.7	93.0
Өрхийн тоо, оны эцэст	мян.өрх	869.8	897.9	103.2
Бүх шатны боловсролын сургалтын байгууллагад суралцагчид, хичээлийн жилийн эхэнд	мян.хүн	994.6	1 089.9	109.6
Эдийн засгийн идэвхтэй хүн ам	мян.хүн	1 275.6	1 273.9 ¹	99.9
Ажиллагчид	мян.хүн	1 147.8	1 146.2 ¹	99.9
Ажилгүй иргэд	мян.хүн	127.8	127.7 ¹	99.9
Бүртгэлтэй ажилгүй иргэд	мян.хүн	34.4	20.8	60.5
Ажилгүйдлийн түвшин	хувь	10.0	10.0 ¹	100.0
ДНБ, оны үнээр	тэрбум төг	23 942.9	36 897.6	154.1
ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр	тэрбум төг	16 035.9	19 039.6	118.7
ҮНО, оны үнээр	тэрбум төг	21 971.1	32 738.4	149.0
ҮНО, 2010 оны зэрэгцүүлэх үнээр	тэрбум төг	14 837.2	16 976.0	114.4
1 хүнд ногдох ДНБ, оны үнээр	мян.төг	7 910.0	11 566.5	146.2
1 хүнд ногдох ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр	мян.төг	5 297.8	5 968.4	112.7
1 хүнд ногдох ДНБ, оны үнээр, Дэлхийн Банкны атласын аргаар	ам. доллар	3 854.0	4 294.0	111.4
1 хүнд ногдох ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, Дэлхийн Банкны атласын аргаар	ам. доллар	2 602.0	2 227.0	85.6
1 хүнд ногдох ҮНО, оны үнээр	мян.төг	7 113.0	10 105.4	142.1
1 хүнд ногдох ҮНО, 2010 оны зэрэгцүүлэх үнээр	мян.төг	4 803.5	5 240.0	109.1
Инфляцын жилийн түвшин, оны эцэст	хувь	1.3	5.2	400.0
Мөнгө M2	тэрбум төг	12 158.5	20 833.8	171.4
Төгрөгийн ам доллартой харьцах жилийн дундаж ханш	төг	2 147.7	2 727.3	127.0
Улсын нэгдсэн төсөв				
Нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламж	тэрбум төг	5 896.9	10 801.6	183.2
Нийт зарлага, цэвэр зээл	тэрбум төг	9 564.7	11 429.4	119.5
Төсвийн нийт тэнцвэржүүлсэн тэнцэл	тэрбум төг	-3 660.8	- 627.8	17.1

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016	2019*	$\frac{2019}{2016}$ %
Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын ДНБ-д эзлэх хувь	хувь	24.6	32.4	131.7
Улсын нэгдсэн төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь	хувь	39.9	31.0	77.7
Хөрөнгө оруулалт	тэрбум төг	7 185.2	13 830.1	192.5
Гадаад худалдааны нийт эргэлт	сая ам.доллар	8 274.5	13 747.2	166.1
Экспорт	сая ам.доллар	4 916.3	7 619.8	155.0
Импорт	сая ам.доллар	3 358.1	6 127.4	182.5
Гадаад худалдааны тэнцэл	сая ам.доллар	1 558.2	1 492.3	95.8
Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл, оны үнээр	тэрбум төг	15 663.8	29 482.2	188.2
Уул уурхай, олборлолт	тэрбум төг	8 711.4	16 269.9	186.8
Боловсруулах үйлдвэрлэл	тэрбум төг	5 210.1	10 319.9	198.1
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	тэрбум төг	1 427.5	2 514.2	176.1
Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	тэрбум төг	314.8	378.1	120.1
Нэг өрхийн сарын дундаж орлого	мян.төг	944.2	1 369.6	145.1
Нэг өрхийн сарын дундаж зарлага	мян.төг	966.2	1 447.0	149.8
Мал	мян.толгой	61 549.2	70 969.3	115.3
Хураасан ургац				
Үр тариа	мян.т	483.5	433.3	89.6
Төмс	мян.т	165.3	192.2	116.3
Хүнсний ногоо	мян.т	94.4	99.5	105.4
Барилга угсралт, их засварын ажил	тэрбум төг	3 356.3	4 747.5	141.5
Бүх төрлийн тээврээр тээсэн ачаа	мян.т	40 400.2	68 997.5	170.8
Бүх төрлийн тээврээр зорчигчид, давхардсан тоогоор	сая хүн	264.0	173.0	65.5
Дотоод худалдааны салбарын нийт борлуулалт	тэрбум төг	16 773.6	23 859.9	142.2
Бөөний худалдаа	тэрбум төг	7 820.9	13 191.4	168.7
Жижиглэн худалдаа	тэрбум төг	8 952.7	10 668.5	119.2

* 2019 онд Хөдөлмөрийн статистикийн үзүүлэлт тооцох аргачлал өөрчлөгдсөн.

ХҮН АМЫН ӨСӨЛТ, ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨН



2016 он 3 119.9

мян.хүн

2019 он 3 299.7

2%

Жилийн
дундаж өсөлт

Төрөлт



2019 онд

78.6

мянган хүүхэд
төржээ.

2016 оноос
0.1 % буурч

2017 оноос
5.1 % өсөж

2018 оноос
0.8 % өсөж

2019 онд

897.9

мянган өрх

1 өрхөд
ногдох хүн

3.6

ХҮН АМ ЗҮЙН АЧААЛАЛ



57

Хүн амын
голч нас
2019 онд

27.5

2016 онтой харьцуулахад

15 хүртэлх
насны хүүхэд

15 - 64
насны

65 ба түүнээс
дээш насны

2.3

пунктээр
өссөн

2.6

пунктээр
буурсан

0.3

пунктээр
өссөн

ХОТЫН ХҮН АМ, НЯГТРАЛ

2019 онд хот, тосгонд амьдарч байгаа



2.2 сая хүн амын
1.5 сая нь Улаанбаатарт
байна.

2016 оноос

4.5%

92.6 мянган
хүнээр өссөн.

Улаанбаатар хотод
хүн амын нягтаршил
1км² талбайд


317.3*

хүн
*2018 оны дүн

ХҮН АМ, НИЙГМИЙН БАЙДАЛ

Монгол Улсын хүн ам 2020 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар 3.3 сая болж, 2016 оноос 179.8 (5.8%) мянган хүнээр нэмэгдсэн байна. Хүн амын 67.9 хувь буюу 2.2 сая хүн хот, тосгонд амьдарч байгаа нь 2016 оноос 92.6 мянган хүн буюу 4.5 хувиар өсжээ.

Зураг 1. Монгол Улсын хүн амын тоо, мянган хүн



Хүн амын дундаж наслалт 1992 онд 62.7 жил байсан бол 2018 он хүртэлх 26 жилийн хугацаанд 7.4 жилээр нэмэгдэж 70.2 жил болжээ. Гэвч эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү 1992 онд 4.2 жил байсан бол 2018 онд 9.7 жил болж холдсон байна. Энэ нь Дэлхийн дунджаас 2 дахин өндөр байна.

Хүснэгт 1. Хүн амын тоо, хүн ам зүйн зарим үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	2016	2017	2018	2019*
Хүн ам зүйн ачаалал-Бүгд	50.8	52.0	54.6	57.0
Хүүхэд	45.0	45.9	48.3	50.3
Хөгшид	5.8	6.1	6.3	6.7
Хүн амын голч нас	27.2	27.4	27.4	27.5
Хүйсийн харьцаа	96.4	96.4	97.1	97.4

Сүүлийн жилүүдэд хүн ам зүйн ачаалал нэмэгдэж, эдийн засгийн идэвхтэй 100 хүнд ногдох хүүхэд, хөгшдийн тоо 2019 онд 57.0 болж, 2016 оноос 6.2-оор өссөн нь төрөлт нэмэгдсэнтэй холбоотой байна.

Улсын хэмжээнд 2019 оны урьдчилсан дүнгээр 897.9 мянган өрх байгаагийн 67.6 хувь нь хотод, 32.4 хувь нь хөдөөд байгаа бөгөөд улсын дунджаар нэг өрхөд 3.6 хүн ногдож байна.

Хүснэгт 2. Монгол Улсад оршин суугаа хүн амын тоо, хүн амын нягтрал, аймаг, нийслэлээр, 2019*

Аймаг, нийслэлийн нэр	Хүн амын жилийн өсөлт, бууралт, хувь	Хотын хүн амын нийт хүн амд эзлэх хувь	Хүн амын нягтрал (2018 он)
Бүгд	0.2	67.9	2.1
Баруун бүс	-0.9	33.3	1.0
Баян-Өлгий	0.1	37.5	2.3
Говь-Алтай	-1.5	32.6	0.4
Завхан	-1.4	22.6	0.9
Увс	-0.8	36.5	1.2
Ховд	-1.4	34.8	1.2
Хангайн бүс	-0.8	41.1	1.6
Архангай	-1.9	22.0	1.7
Баянхонгор	-0.6	35.9	0.8
Булган	-2.6	25.4	1.3
Орхон	1.2	96.3	132.5
Өвөрхангай	-1.6	28.3	1.9
Хөвсгөл	-0.4	32.8	1.3
Төвийн бүс	-1.4	45.5	1.1
Говьсүмбэр	-1.0	59.3	3.2
Дархан-Уул	-2.1	80.3	32.1
Дорноговь	0.4	64.1	0.6
Дундговь	-0.8	26.7	0.6
Өмнөговь	1.1	37.7	0.4
Сэлэнгэ	-2.2	34.6	2.7
Төв	-3.3	18.2	1.3
Зүүн бүс	-0.5	41.4	0.8
Дорнод	-0.6	56.3	0.7
Сүхбаатар	0.6	29.5	0.8
Хэнтий	-1.2	35.3	1.0
Улаанбаатар	1.7	100.0	317.3

Өрх толгойлсон эх, эцэг 2019 онд 87.6 мянга болж 2016 оноос 10.7 (10.9%) мянгаар буурсан байна. Нийт өрх толгойлсон эх, эцгийн 79.7 хувь нь эмэгтэйчүүд, 20.3 хувь нь эрэгтэйчүүд байна. Сүүлийн дөрвөн жилийн хугацаанд өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо 10.2 хувь, эрэгтэйчүүдийн тоо 13.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 3. 18 хүртэлх насны хүүхэдтэй, өрх толгойлсон эцэг, эх

Үзүүлэлт	2016	2017	2018	2019*
Бүгд	46 077	46 421	43 691	41 793
Эцэг	7 930	8 273	7 421	7 548
Эх	38 147	38 148	36270	34 245

ГЭРЛЭЛТ, ЦУЦЛАЛТ 2019 он



20.0

мян.хос
гэрлэж

4.2

мян.хүн
цуцлуулж

18, түүнээс дээш насны
1000 хүнд ногдох гэрлэлт

2016 он 2019 он

8.5 9.8

Гэр бүл цуцлалт 1000 хүнд ногдох



2.0 2.0

ҮРЧЛЭЛТ, ӨНЧИН ХҮҮХЭД

2019 он



1.6

мян.хүүхэд
үрчлүүлж

36.8

мян.өнчин
хүүхэд

ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ, ЭХ

2019 он



87.6 69.8 17.8

мянган
эцэг, эх

мянган
эх

мянган
эцэг

2016 онтой
харьцуулахад

10.9% буурсан.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД 2019 он



3.4% 46.4 60.7

нийт
хүн амын

мян.хүн
төрөлхийн

мян.хүн
олдмол

2016 оноос

2017 оноос

2018 оноос

6.1%

3.3%

1.3%

өссөн


өссөн

өссөн

Хөгжлийн бэрхшээлтэй
0-17 насны хүүхэд

11610

Зураг 2. Өрх толгойлсон эх, эцэг



Сүүлийн 4 жилийн дунджаар улсын хэмжээнд нийт 76.6 мянган эх амаржиж, 77.5 мянган хүүхэд төрүүлсний 77.1 мянга нь амьд төрөлт, 445 нь амьгүй төрөлт байна. 10 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн харьцаа сүүлийн 4 жилийн дунджаар 31.4 болж, өмнөх 4 жилийн дунджаас 6.1-ээр мөн буурчээ. Эхийн эндэгдлийн харьцаа 2019 онд 23.0 болж, “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр (2017-2021)-ийн шалгуур үзүүлэлтэд хүрсэн байна.



Зураг 3. Эхийн эндэгдэл



“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтэд 2020 он гэхэд 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 15 болгох зорилт тавьсан бөгөөд 2019 онд 16 болж хараахан биелээгүй,

харин нялхсын эндэгдлийн түвшинг 13 болгох, нярайн эндэгдлийн түвшинг 9 болгох зорилт тус бүр 2019 оны байдлаар биелсэн байна.

Зураг 4. Хүүхдийн эндэгдлийн түвшин, 1000 амьд төрөлтөд ногдох



Сүүлийн 20 гаруй жилд Монгол Улсын хүн амын өвчлөлийн дийлэнх хувийг урьдчилан сэргийлж болох халдварт бус өвчин эзэлж байна. Хүн амын халдварт бус өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаанд 2019 оны байдлаар амьсгалын тогтолцооны, зүрх, судасны, хоол боловсруулах, шээс, бэлгийн тогтолцооны, мэдрэлийн тогтолцооны өвчнүүд орж байна.


Хүснэгт 4. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн түвшин тэргүүлэх 5 шалтгаан, 10 000 хүнд ногдохоор

Өвчний бүлэг	2012-2015	2016-2019
	оны дундаж	оны дундаж
Нийт халдварт бус өвчин	2 562	2 753
Амьсгалын тогтолцооны өвчин	387	460
Зүрх, судасны тогтолцооны өвчин	397	417
Хоол боловсруулах эрхтний өвчин	336	339
Шээс бэлгийн тогтолцооны өвчин	311	320
Мэдрэлийн тогтолцооны өвчин	179	213

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛ, 2019




БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, мянган хүн



ААНБ-Д АЖИЛЛАГЧДЫН ЦАЛИН ХӨЛС

Сарын дундаж цалин, мянган төгрөг



Хүснэгт 5. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт, мянган хүн

Үзүүлэлт	2016	2017	2018	2019 ¹
Бүгд				
Ажиллах хүч	1 275.6	1 357.4	1 358.6	1 273.9
Ажиллагчид	1 147.8	1 238.3	1 253.0	1 146.2
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч	3.6	9.9	8.0	15.1
Ажилгүй хүн	127.8	119.1	105.6	127.7
Бүртгэлтэй ажилгүй иргэд ²	34.4	25.5	25.0	20.8
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	831.4	863.0	868.0	832.2
Боломжит ажиллах хүч	-	-	-	58.8
Бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам	-	-	-	773.4
Ажиллах хүчний оролцооны түвшин, %	60.5	61.1	61.0	60.5
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, %	54.5	55.8	56.3	54.4
Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин, %	-	-	-	15.1
Ажилгүйдлийн түвшин, %	10.0	8.8	7.8	10.0
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин, %	-	-	-	11.2
Ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин, %	-	-	-	14.0

¹ Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох шинэчилсэн аргачлалаар тооцсон


² Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Сүүлийн жилүүдэд ажиллагчдын тоо өсөж байгаа хэдий ч ажилгүй иргэдийн тоо дорвитой буурахгүй, мөн хөдөлмөр эрхлэлтийн түвшин нэмэгдэхгүй байна. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2019 онд 54.4 хувьтай байгаа нь 2016 оноос 0.1 пунктээр буурсан байна. Хүн амын тоо жилээс жилд өсөж байхад хөдөлмөр эрхлэлтийн түвшин буурч буй байдал нь эдийн засаг хөдөлмөрийн насны хүн амынхаа хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээг хангаж чадахгүй байгааг илэрхийлж байна.


ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ

	мянган хүн	
	2016 он	2019 он
Ажиллах хүч	1275.6	1273.9
Ажиллагчид	1147.8	1146.2
Ажилгүй хүн	127.8	127.7
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	54.5%	54.4%
Ажилгүйдлийн түвшин	10.0%	10.0%

БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН БОЛОВСРОЛ 2019 ОНД




САРЫН ДУНДАЖ ЦАЛИН, хүйсээр, мянган төгрөг



Ажиллах хүчний оролцооны түвшин 2019 онд 60.5 хувь байгаа нь 2016 оны түвшинд байна. Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин эрэгтэйчүүдийнхээс доогуур байна. Энэ нь Монгол улсын хөдөлмөрийн зах зээлд эмэгтэйчүүдийн бүтээмжтэй хөдөлмөр эрхлэх боломж эрэгтэйчүүдийнхээс бага байгааг илэрхийлж байна.

Зураг 5. Хөдөлмөрийн дутуу ашиглалт, насны бүлгээр, хувиар, 2019



Хөдөө аж ахуйн салбарт ажиллагчид 2016-2019 онд 30.4 хувиас 25.3 хувь хүртэл буурчээ. Нийт ажиллагчдын 30 орчим хувь нь бүтээмж, цалин хөлс харьцангуй бага хөдөө аж ахуйн салбарт ногдсон хэвээр байна. Ажиллах хүчний багтаамж багатай уул уурхайн салбарт нийт ажиллагчдын 5.1 хувь нь ажиллаж, 2016 оноос 1.7 пунктээр нэмэгдсэн байна..

Ажилгүй иргэдийн тоо дорвитой буурахгүй, цаашлаад 15-24 насны залуучуудын ажилгүйдлийн түвшин улсын дунджаас 2-3 дахин өндөр байна.

Хүснэгт 6. Бүртгэлтэй ажилгүй иргэд, хөдөлгөөнөөр, мянган хүн

Үзүүлэлт	2008- 2011 оны дундаж	2012- 2015 оны дундаж	2016- 2019 оны дундаж	2016-2019 2012-2015
Бүртгэлтэй ажилгүй иргэд	40.9	37.1	26.4	71.2
Шинээр бүртгүүлсэн иргэд	67.6	101.0	97.7	96.8
Ажилд зуучлагдан орсон иргэд	61.9	39.1	25.6	65.5
Ажил хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан иргэд	14.7	59.2	75.1	126.9

Нэг ажилтанд ногдох сарын дундаж цалин 2019 оны байдлаар 1.1 сая төгрөг болж 2016 оноос 262.4 (30.5%) мянган төгрөгөөр нэмэгджээ. Ажиллагчдын медиан цалин 2019 оны байдлаар 905.0 мянган төгрөг байгаа нь улсын дундаж цалингаас 337.7 (27.2%) мянган төгрөгөөр бага байна. Дундаж цалин болон медиан цалингийн харьцаа 2019 онд 2016 оноос 5.6 пунктээр холдсон нь ажиллагчдын цалингийн ялгаа ихэссэнийг харуулж байна.

Хүснэгт 7. Ажиллагчдын сарын дундаж цалин, байгууллагын хариуцлагын хэлбэрээр, мянган төгрөг

Үзүүлэлт	2012- 2015 оны дундаж	2016- 2019 оны дундаж	2016-2019 2012-2015
Бүгд	734.3	983.4	133.9
Хувьцаат компани	807.0	1 117.4	138.5
Хязгаарлагдмал хариуцлагатай компани	789.5	1 075.1	136.2
Бүх гишүүд нь хариуцлагатай нөхөрлөл	485.3	707.5	145.8
Зарим гишүүд нь хариуцлагатай нөхөрлөл	452.4	659.8	145.8
Хоршоо	280.8	478.8	170.5
Төрийн өмчит үйлдвэрийн газар	830.9	1 178.8	141.9
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	584.9	743.8	127.2
Төсөвт байгууллага	672.3	791.1	117.7
Төрийн бус байгууллага	564.7	786.3	139.2
Бусад (хувийн цэцэрлэг, сургууль гэх мэт)	858.0	1 151.1	134.1

Хүснэгт 8. Ажиллагчдын сарын дундаж цалин, хүйсээр, мянган төгрөг

Үзүүлэлт	2012-2015 оны дундаж	2016-2020 оны дундаж	2016-2019 2012-2015
Улсын дундаж	734.3	983.4	133.9
Эрэгтэй	792.3	1 066.6	134.6
Эмэгтэй	676.7	899.0	132.8

Ядуурлын түвшин 2018 оны байдлаар 28.4 хувь болж, 904.9 мянган хүн ядууралд өртсөн байна. Ядуурал 2010 оноос эрчимтэй буурсан хэдий ч 2016 оноос зогсонги байдалтай байна. Ядуурлын түвшин 2016 онд 29.6 хувь байсан ба 2018 онд хотод ядуурал 27.1 хувиас 27.2 хувь болж 0.1 пунктээр өсөж, харин хөдөөд 34.9 хувиас 30.8 хувь болж 4.1 пунктээр буурсан байна.

Хүснэгт 9. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, улсын дундаж, хот, хөдөөгөөр


Үзүүлэлт	Ядуурлын хамралтын хүрээ		Ядуурлын гүнзгийрэлт		Ядуурлын мэдрэмж	
	2016	2018	2016	2018	2016	2018
	хувь					
Улсын дундаж	29.6	28.4	7.7	7.2	2.9	2.7
Хот	27.1	27.2	7.2	7.2	2.8	2.8
Үүнээс:						
Улаанбаатар	24.8	25.9	6.4	6.7	2.5	2.6
Хөдөө	34.9	30.8	8.8	7.2	3.2	2.4

Хөдөөд ядуурал эрчимтэй бүүрч чадсан ч нийт хүн амын гуравны хоёр нь хот суурин газарт амьдарч байгаагаас хот суурин газарт амьдарч буй ядуучуудын тоо нэмэгдэж байна. Ядуу хүн амын 55.2 хувь 2010 онд хот суурин газарт амьдарч байсан бол 2018 онд 63.5 хувь болон өссөн байна.



Боловсролын түвшин өндөр байх нь ядууралд өртөх магадлалыг бууруулж байна. Дийлэнх ядуу хүмүүс сургуулиас завсардсан эсвэл бүрэн дунд, түүнээс бага боловсролтой байна. Харин чинээлэг 20 хувийн хүн амын тал нь дээд боловсролтой байна.

Хүн амын хамгийн чинээлэг 20 хувийн өрхийн нэг хүнд ногдох сарын орлого нь ядуу 20 хувьд хамаарах нэг хүнд ногдох сарын орлогоос 6 дахин их байна. Хүн амын хамгийн чинээлэг 20 хувийнхны хэрэглээний дундаж хэмжээ ядуу 20 хувийнхнаас 5 дахин их байсаар байгаа нь хүн амын дундах хэрэглээний тэгш бус байдал буурахгүй байгааг илтгэж байна.

НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО, төгрөг




■ НИЙТ ХҮН АМЫН 28.4 ХУВЬ ЯДУУ АМЬДАРЧ БАЙНА.




Нийт ядуу хүн амын 5 хүн тутмын 2 нь Улаанбаатар хотод амьдарч байна.

НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГА, төгрөг



ЯДУУРЛЫН ХАМРАЛТЫН ХҮРЭЭ



Орлогын бүрэлдэхүүн хэсгүүдийн ядуурлын өөрчлөлтөд үзүүлж буй нөлөө, 2016-2018 он

	Пункт	Өөрчлөлт
Цалин хөлсний орлого	0.5	↑
ХАА-н орлого	-0.8	↓
ХАА-н бус орлого	0.1	↑
Нийгмийн хамгааллын шилжүүлгийн орлого	-1.3	↓
Хөрөнгийн орлого	0.8	↑
Мөнгөн шилжүүлгийн орлого	-0.2	↓

Хүснэгт 10. Нэг өрхийн сарын дундаж нийт орлого, оны үнээр, төгрөг

Орлогын төрөл	2012-2015	2016-2019	2016-2019
	оны дундаж	оны дундаж	2012-2015
	төгрөг		хувь
Нийт орлого	976 662	1 132 583	116.0
1. Мөнгөн орлого	880 985	1 033 214	117.3
Цалин хөлс	453 942	560 956	123.6
Тэтгэвэр, тэтгэмж	153 706	196 000	127.5
Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого	182 538	175 603	96.2
Бусад орлого	90 799	100 655	110.9
2. Бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүн	41 461	54 194	130.7
3. Хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн	54 216	45 176	83.3

Нэг өрхийн сарын дундаж нийт орлого 2019 онд 1.4 сая төгрөг болж, 2016 оноос 425.5 (45.1%) мянган төгрөгөөр, зарлага 1.4 сая төгрөг болж, 2016 оноос 480.8 (49.8%) мянган төгрөгөөр нэмэгджээ. Нэг өрхийн сарын дундаж орлого, зарлага өсөлтөд инфляцаас хамаарсан өсөлт голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 11. Нэг өрхийн сарын дундаж нийт зарлага, оны үнээр

Зарлагын төрөл	2012-2015	2016-2019	2016-2019
	оны дундаж	оны дундаж	2012-2015
	төгрөг		хувь
Нийт зарлага	980 826	1 186 572	121.0
1. Мөнгөн зарлага	885 150	1 087 202	122.8
Хүнсний зүйлийн зарлага	230 808	240 278	104.1
Хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага	631 887	821 355	130.0
Бусдад өгсөн бэлэг, тусламж	22 455	25 569	113.9
2. Бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүн	41 461	54 194	130.7
3. Хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн	54 215	45 176	83.3

Өрхийн нийт орлого, зарлагын харьцааг харахад 2016-2019 онд өрхийн нийт зарлагын хэмжээ орлогоосоо 2.3-5.6 хувиар илүү байна. Энэ нь өрхүүд хуримтлал үүсгэж чадах хэмжээний орлого олж чадахгүй байгааг харуулж байна.

НИЙГМИЙН ДААТГАЛ

Нийгмийн даатгалын сангийн орлого, тэрбум.төг



2016	1 314.6	2016 оноос 2.1 дахин өссөн
2019*	2 822.5	

Нийгмийн даатгалын сангийн зарлага, тэрбум.төг



2016	1 697.7
2019*	2 507.1

2019* онд нийгмийн даатгалын сангаас

1 837.4 тэрбум төгрөгийг тэтгэвэрт зарцуулсан нь 2016 оноос **40.7 %**-иар өссөн.



БОЛОВСРОЛ

	2016	2019
 Цэцэрлэг	1 354	1 439
 Хүүхдийн тоо, (мян.хүн)	219.8	242.6
 Ерөнхий боловсролын сургууль	778	820
 Суралцагчид, (мян.хүн)	552.0	640.4
 Их, дээд сургууль, коллеж	95	95
 Суралцагчид, (мян.хүн)	157.1	148.4

АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ

	2016	2019
Тохиолдсон гамшигт үзэгдэл	4 884	5 123
 -Объектын	3 710	4 301
 -Ой хээрийн	141	121
 -Хүчтэй цасан болон шороон шуурга	14	56
 -Аадар бороо, үерийн аюул	21	35

Хүснэгт 12. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага төрлөөр, тэрбум төгрөгөөр

Үзүүлэлт	2012-2015 оны дундаж	2016- 2019 оны дундаж	<u>2016-2019</u> <u>2012-2015</u>
Нийгмийн даатгалын сангийн орлого	1 036.5	1 896.5	183.0
Тэтгэврийн даатгалын сангийн	637.5	1 214.2	190.5
Тэтгэмжийн даатгалын сангийн	65.6	121.2	184.8
Эрүүл мэндийн даатгалын сангийн	212.6	358.0	168.4
ҮОМШӨ ¹ -ний даатгалын сангийн	91.0	164.5	180.8
Ажилгүйдлийн даатгалын сангийн	29.8	38.6	129.5
Нийгмийн даатгалын сангийн зарлага	1 182.5	2 160.9	182.7
Тэтгэврийн даатгалын сангийн	919.8	1 728.4	187.9
Тэтгэмжийн даатгалын сангийн	66.7	121.1	181.6
Эрүүл мэндийн даатгалын сангийн	151.6	344.0	2.3 ¹
ҮОМШӨ ¹ -ний даатгалын сангийн	28.9	80.8	2.8 ¹
Ажилгүйдлийн даатгалын сангийн	15.5	58.6	3.7 ¹

¹ Дахин их

Нийгмийн даатгалын сангийн орлого 2019 онд 2.8 их наяд төгрөгт хүрч, 2016 оноос 2.1 дахин, зарлага 2.5 их наяд төгрөгт хүрч, 47.7 хувиар нэмэгджээ. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага нэмэгдэхэд тэтгэврийн даатгалын сангийн орлого 2.1 дахин, зарлага 40.8 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Тэтгэвэр авагчдын тоо 2019 онд 418.4 мянган хүн болж, 2016 оноос 11.0 хувиар нэмэгдэхэд өндөр настны тэтгэвэр авагчид 15.6 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

НИЙГМИЙН ХАЛАМЖ

Нийгмийн халамжийн сангийн орлого, тэрбум.төг



2016	275.9
2019*	680.1

Нийгмийн халамжийн сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн хэмжээ, нэг хүнд ногдохоор, мян.төг



Халамжийн тэтгэвэр



Тэтгэмж, тусламж



Хөнгөлөлт

2016	107.6	19.2	9.9
2019*	153.2	22.0	13.9

ЭРҮҮЛ МЭНД



Халдварт өвчнөөр өвчлөгчид, мянган хүн

2016	69.7	2016 оноос
2019	45.2	35.2 % буурсан

2016-2019 оны дундаж



Амьсгалын замаар дамжих, хувиар

43.3 %



Бэлгийн замаар дамжих, хувиар

35.4 %

ГЭМТ ХЭРЭГ

Бүртгэгдсэн гэмт хэрэг



2016	27 167	2016 оноос
2019	31 524	16.0 % өссөн

ОРОН СУУЦ, НИЙТИЙН АЖ АХУЙ



Ашиглалтад оруулсан орон сууц

2016	15 281
2019	13 528

2016-2019 онд

48 668 айлын сууц ашиглалтад оруулсан байна.



Хог тээврийн машин

2016	810
2019	862

Хог устгах цэг

2016	394
2019	384

Хүснэгт 13. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчид, олгосон тэтгэврийн хэмжээ, төрлөөр

Үзүүлэлт	2012-2015 оны дундаж	2016-2019 оны дундаж	<u>2016-2019</u> <u>2012-2015</u>
Тэтгэвэр авагчдын тоо , мянган хүн	351.2	403.8	115.0
Өндөр настан	241.5	292.9	121.3
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	68.4	71.8	104.9
Тэжээгчээ алдсан	26.6	21.9	82.4
Цэргийн тэтгэвэр	14.7	17.3	117.3
Олгосон тэтгэврийн хэмжээ, тэрбум төг.	945.6	1 556.9	164.6
Өндөр насны	675.6	1 164.2	172.3
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн	144.4	212.8	147.3
Тэжээгчээ алдсаны	53.0	65.7	123.8
Цэргийн тэтгэвэрт	72.5	114.3	157.6

Хүснэгт 14. Нийгмийн халамжийн сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн хэмжээ, нэг хүнд ногдохоор


Үзүүлэлт	2012-2015 оны дундаж	2016-2019 оны дундаж	<u>2016-2019</u> <u>2012-2015</u>
Нийгмийн халамжийн тэтгэвэр	105 105	121 625	115.7
Нийгмийн халамжийн тэтгэмж, тусламж	7 467	17 979	2.4 ¹
Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт	5 836	12 160	2.1 ¹

Нийгмийн халамжийн сангийн зардал 2016-2019 онд дунджаар 379.1 тэрбум төгрөгт хүрч, 2012-2015 оны дунджаас 61.1 хувиар нэмэгдсэн байна.

Шинжлэх ухаан технологийн сангаас 2019 онд 49.4 тэрбум төгрөгийг зарцуулсан нь 2016 оноос 16.1 (48.4%) тэрбум төгрөгөөр өсөж, ДНБ-ний 0.1 хувийг эзэлж байна. Улсын төсвөөс санхүүжүүлсэн эрдэм шинжилгээний ажил 2016-2019 онд дунджаар 306 болж, 2012-2015 оны дунджаас 133 (30.3%)-аар буурсан байна.

ЦАГ УУР

АЙМГИЙН ТӨВ, НИЙСЛЭЛ ХОТЫН АГААРЫН
ДУНДАЖ ХЭМ



АГААРЫН БОХИРДОЛ

Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулагч бодисын
агууламж, бодисын төрлөөр, мг/м3

Хүхэрлэг хийн агууламж



2016 0.034

2019 0.031




Азотын давхар ислийн агууламж



2016 0.039

2019 0.036

	2016	2019
10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж	0.128	0.116
2.5 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж	0.079	0.060




Хүснэгт 15. Шинжлэх ухааны салбарын үндсэн үзүүлэлт

Үзүүлэлт	2012-2015 оны дундаж	2016-2019 оны дундаж	2016-2019 2012-2015
Байгууллагын тоо	68	62	88.2
Ажиллагчид	4 245	4 254	97.5
Эмэгтэй	2 138	2 126	98.3
Салбарын нийт зардал, сая төгрөг	39 747.1	39 415.3	106.6
Техникийн ШУ	8 307.1	7 433.9	80.0
Байгалийн ШУ	11 628.7	9 019.5	105.7
ХАА-н ШУ	5 651.0	4 708.5	101.3
Анагаах ухааны ШУ	3 871.0	1 558.4	105.8
Нийгмийн ШУ	8 087.4	6 645.2	118.7
Бусад	2 201.9	10 049.8	182.3

Боловсролын салбарт цэцэрлэгийн тоо тогтмол нэмэгдэж байгаа хэдий ч цэцэрлэгийн бүлэг дүүргэлт өндөр, цэцэрлэгт хамрагдвал зохих 2-5 насны хүүхдийн хамрагдалт бага хэвээр байна. Мөн ерөнхий боловсролын сургуулийн тоо тогтмол нэмэгдэж байгаа хэдий ч бага ангийн бүлэг дүүргэлт өндөр, нэг багшид ногдох суралцагчдын тоо нэмэгдсээр байна.

Зураг 6. ЕБС-ийн бүлэг дүүргэлт, хүүхдээр



ГАЗРЫН НЭГДМЭЛ САН

Монгол Улсын газрын нэгдсэн сан, үндсэн ангиллаар, мян.га

Хөдөө аж ахуйн газар



2016 114 931.1

2019* 114 809.2

Зам, шугам, сүлжээний газар



2016 473.8

2019* 474.3

Усны сан бүхий газар



2016 686.1

2019* 686.1

Хот, тосгон, бусад суурин газар



2016 753.6

2019* 859.7

Ойн сан бүхий газар



2016 14 334.3

2019* 14 341.4

Тусгай хэрэгцээний газар




2016 25 232.7

2019* 25 240.9



Улсын хэмжээгээр 2019 онд 31.5 мянган гэмт хэрэг бүртгэгдсэн нь 2016 оноос 4.4 (16.0%) мянгаар нэмэгдэж, 16, түүнээс дээш насны 10 000 хүнд ногдох гэмт хэрэг улсын дунджаар 148 болж, 2016 оноос 17 (13.0%)-гоор өссөн байна. Гэмт хэргийн улмаас учирсан нийт хохирол 2016-2019 онд дунджаар 179.2 тэрбум төгрөг болж, 2012-2015 оны дунджаас 53.0 (42.0%) тэрбум төгрөгөөр нэмэгдэж, харин нөхөн төлүүлэлт дунджаар 48.7 тэрбум төгрөг болж, 8.6 (15.0%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Зураг 7. Бүртгэгдсэн гэмт хэрэг



Хүснэгт 16. Гэмт хэргийн улмаас хохирсон хүн, зонхилох гэмт хэргийн төрлөөр

Үзүүлэлт	2012-2015 оны дундаж	2016-2019 оны дундаж	2016-2019 / 2012-2015
Хохирсон хүн-Бүгд	25433	32303	127.0
Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	543	631	116.2
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	7577	8834	116.6
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	11534	19027	165.0
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	2272	1637	72.1
Олон нийтийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	2070	757	36.6

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

Дэлхийн санхүү эдийн засгийн хүндрэл, түүний дотор олборлох салбарын түүхий эдийн үнийн уналт болон гадаадын шууд хөрөнгө оруулалтын бууралт зэргээс шалтгаалж эдийн засгийн өсөлт 2012-2016 онд 12.3-1.2 хувь хүртэл буурч байсан. Сүүлийн жилүүдэд эдийн засаг аажмаар сэргэж байна.

Манай улсын эдийн засгийн өсөлт 2019 онд урьдчилсан гүйцэтгэлээр 5.1 хувь болж, 2016 оноос 3.9 пунктээр өссөн байна.


Эдийн засаг сүүлийн 4 жилд сэргэхэд аж үйлдвэр, барилга, бөөний болон жижиглэн худалдааны салбарын өсөлт голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 17. ДНБ-ий жилийн өсөлт, бууралт, хувиар


Салбар	2012-2015		2016-2019*	
	оны жилийн дундаж өсөлт, (%)	2019*	оны жилийн дундаж өсөлт, (%)	
ДНБ	8.6	5.1	4.7	
Хөдөө аж ахуй	16.2	8.4	5.2	
Уул уурхай, олборлолт	15.1	(0.6)	0.0	
Боловсруулах үйлдвэрлэл	6.5	11.0	11.4	
Цахилгаан, хий, уур, усан хангамж	4.5	7.4	5.6	
Барилга	22.2	5.8	4.3	
Бөөний болон жижиглэн худалдаа	3.8	7.2	3.4	
Тээвэр, мэдээлэл холбоо	7.0	4.7	8.2	
Үйлчилгээний бусад	8.6	5.6	4.2	
Бүтээгдэхүүний цэвэр татвар	(3.0)	5.4	1.1	

Нэг хүнд ногдох ДНБ, Дэлхийн Банкны атласын аргаар, 2019 онд урьдчилсан гүйцэтгэлээр 4294 америк доллар болж, 2016 оноос 440.6 америк доллароор буюу 11.4 хувиар өссөн байна.


ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, хувиар



МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ(М2), 2016-2019 оны эцэст, тэрбум төгрөг



ГАДААД ХУДАЛДАА, сая америк доллар




Хүснэгт 18. ДНБ-ий салбарын бүтэц, дүнд эзлэх хувиар

Салбар	2012-2015 оны жилийн дундаж	2019	2016-2019 оны жилийн дундаж
ДНБ	100.0	100.0	100.0
Хөдөө аж ахуй	12.8	10.9	10.8
Үйлдвэрлэлийн салбар	34.3	42.0	40.6
Уул уурхай, олборлолт	17.1	24.3	23.4
Боловсруулах үйлдвэрлэл	9.8	11.2	10.4
Цахилгаан, хий, уур, усан хангамж	2.0	2.4	2.5
Барилга	5.4	4.1	4.2
Үйлчилгээний салбар	52.9	47.1	48.6
Бөөний болон жижиглэн худалдаа	17.9	16.2	16.1
Тээвэр, мэдээлэл холбоо	7.4	6.6	6.9
Үйлчилгээний бусад	27.6	24.3	25.6

Эдийн засгийн бүтцэд өөрчлөлт гарч, үйлдвэрлэлийн салбарын эзлэх хувь 2016-2019 оны дунджаар 40.6 болж, 2012-2015 оны дунджаас 6.3 пункт, үүний дотор уул уурхайн олборлох салбар 23.4 хувь болж, 6.4 пунктээр нэмэгдэж байсан бол хөдөө аж ахуйн салбарынх 10.8 хувь болж, 2.0 пункт, үйлчилгээний салбарынх 48.6 хувь болж, 4.3 пунктээр буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарт уул уурхай, олборлох үйлдвэрийн салбарын эзлэх хувь өндөр байгаа хэдий ч боловсруулах үйлдвэрийн салбарын эзлэх хувь аажим тэлж байгаа эерэг хандлага ажиглагдаж байна. Боловсруулах үйлдвэрлэлийн салбарын ДНБ-д эзлэх хувь 2019 онд 11.2 хувь болж, 4 жилийн өмнөхтэй харьцуулахад 2.4 пунктээр нэмэгдсэн байна.

Зураг 8. ДНБ-д ХАА-н салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь



Хөдөө аж ахуйн салбарт нийт ажиллах хүчний 30 орчим хувь нь ажилладаг боловч тус салбарын эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөө буурч байна.

Хүснэгт 19. Өрх, малчдын тоо, насны бүтэц

Үзүүлэлт	2016	2019*
Малтай өрх, мян.өрх	223.8	233.3
Малчин өрх, мян.өрх	160.7	171.6
Малчдын тоо, мян.хүн	311.4	285.5
- 15-34 насны	108.3	88.5
- 35-54 насны эмэгтэй, 35-59 насны эрэгтэй	172.3	160.1
- 55 ба түүнээс дээш насны эмэгтэй, 60 ба түүнээс дээш насны эрэгтэй	30.9	36.9
Нийт малчдаас эмэгтэй	143.7	119.1
Насны бүтэц %	100.0	100.0
- 15-34 насны	34.8	31.0
- 35-54 насны эмэгтэй, 35-59 насны эрэгтэй	55.3	56.1
- 55 ба түүнээс дээш насны эмэгтэй, 60 ба түүнээс дээш насны эрэгтэй	9.9	12.9

Мал тооллогын 2019 оны дүнгээр манай улсын 171.6 мянган өрх мал маллаж амьжиргаагаа залгуулж байгаа нь 2016 оноос 10.9 (6.8%) мянган өрхөөр нэмэгджээ. ӨНЭЗС-ны 2018 оны дүнгээр малчдын 33.2 хувь нь ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй байсан нь 2016 оноос 4.7 пунктээр буурсан байна. Малчдын ядуурал буурахад малын гаралтай бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж, үнэ өсөн, зах зээлийн нөхцөл сайжирсан нь нөлөөлсний дээр малчдад чиглэсэн засгийн газрын татаас, нийгмийн хамгааллын шилжүүлгүүд эерэг нөлөө үзүүлсэн байна.

Хүснэгт 20. Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, биет хэмжээгээр

Үзүүлэлт	2012-2015 оны дундаж	2019*	2016-2019* оны дундаж
Мах, нядалгааны жингээр, мян.т.	325.7	554.2	473.9
Адууны	35.3	66.4	51.8
Үхрийн	66.4	119.4	109.0
Тэмээний	6.7	12.6	9.0
Хонины	96.0	172.5	142.0
Ямааны	66.8	92.4	83.4
Сүү, мян.т.	723.7	1 074.2	946.9
Гүүний	70.3	112.0	94.1
Үнээний	417.6	627.9	560.9
Ингэний	8.5	11.3	10.8
Хонины	79.7	120.8	105.9
Ямааны	147.6	202.3	175.2
Ноос, ноолуур, мян.т.			
Тэмээний ноос	1.4	2.2	2.0
Хонины ноос	21.5	33.7	31.2
Ямааны ноолуур	7.5	10.9	10.4
Арьс, шир, сая ш.**	11.3	17.6	15.9

**Хурга, ишигний арьсыг оруулсан.

Сүүлийн жилүүдэд малын тоо толгой тасралтгүй өсөж, 2019 онд 71.0 сая толгойд хүрч, 2016 оноос 9.4 (15.3%) саяар нэмэгджээ. Манай улс сүүлийн 4 жилд дунджаар 473.9 мян.т. мах, 946.9 мян.т. сүү, 10.4 мян.т. ноолуур, 33.2 мян.т. ноос, 15.9 сая ширхэг арьс шир үйлдвэрлэж, өмнөх 4 жилээс бэлтгэсэн мах 148.2 мян.т., сүү 223.2 мян.т., ноолуур 2.9 мян.т., бэлтгэсэн арьс, шир 4.6 сая ширхгээр өссөн байна.

Хүснэгт 21. Үйлдвэрлэл, нийлүүлэлтийн харьцаа

Үзүүлэлт		2012- 2015 оны дундаж	2016- 2019 оны дундаж
Нийт нийлүүлэлт, (мян.т) (дотоодын үйлдвэрлэл+импорт)	Улаан буудай	396.4	484.9
	Төмс	197.1	162.4
	Хүнсний ногоо	164.1	171.6
Дотоодын үйлдвэрлэл, мян.т	Улаан буудай	381.5	380.2
	Төмс	190.7	161.3
	Хүнсний ногоо	94.5	93.2
Нийт нийлүүлэлтэд дотоодын үйлдвэрлэлийн эзлэх хувь	Улаан буудай	96.2	78.4
	Төмс	96.8	99.3
	Хүнсний ногоо	57.6	54.3

Зах зээлд 2016-2019 оны дунджаар 484.9 мянган тонн улаан буудай, 162.4 мянган тонн төмс, 171.6 мянган тонн хүнсний ногоо зах зээлд нийлүүлснээс улаан буудайн 78.4 хувь, төмсний 99.3 хувь, хүнсний ногооны 54.3 хувийг дотоодын үйлдвэрлэлээр, үлдсэн хувийг импортын бүтээгдэхүүнээр хангасан байна. Улаан буудайн нийт үйлдвэрлэлд дотоодын үйлдвэрлэлийн эзлэх хувь нь сүүлийн 4 жилийн дунджийг 2012-2015 онтой харьцуулахад 17.8 пункт, хүнсний ногоо 3.3 пунктээр буурч, төмс 2.5 пунктээр өссөн байна.

Хүснэгт 22. Гадаад худалдааны нийт эргэлт, экспорт, импорт, тэнцэл, сая ам.доллар

Үзүүлэлт	2012-2015 оны жилийн дундаж өсөлт	2019*	2016-2019 оны жилийн дундаж өсөлт
Нийт эргэлт	-6.6	13 747.2	13.5
Экспорт	1.1	7 619.8	13.3
Импорт	-12.2	6 127.4	14.3
Тэнцэл (+; -)	-10.8	1 492.3	22.7

Гадаад худалдааны нийт эргэлт 2012-2015 онд жилд дунджаар 6.6 хувиар буурч байсан бол 2016-2019 онд жилд дунджаар 13.5 хувиар өссөн байна. Гадаад

худалдааны нийт эргэлт 2019 онд 13.7 тэрбум америк долларт хүрч, 2016 оноос 5.5 (66.1%) тэрбум америк доллароор өсөхөд экспорт 55.0 хувь, импорт 82.5 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Хүснэгт 23. Экспортын бүтэц, барааны бүлгээр, дүнд эзлэх хувиар

Үзүүлэлт	2016	2017	2018	2019*
Эрдэс бүтээгдэхүүн	70.9	79.6	86.6	83.7
Түүхий болон боловсруулсан арьс шир ангийн үс эдгээрээр хийсэн бүтээгдэхүүн	0.6	0.4	0.2	0.2
Нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн	6.1	5.4	5.8	5.7
Үнэт хагас үнэт чулуу металл гоёлын зүйл	15.5	9.6	2.1	5.5
Бусад	6.9	5.0	5.3	4.9
Нийт дүн	100.0	100.0	100.0	100.0

Гадаад худалдааны тэнцэл 2019 онд 1.5 тэрбум америк долларын ашигтай гарахад экспортын дийлэнх хувийг бүрдүүлдэг уул уурхайн бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнийн өсөлт голлон нөлөөлсөн байна. Манай улсын 2019 оны экспортын 83.7 хувийг эрдэс бүтээгдэхүүн эзэлж, энэ нь 2016 оноос 12.8 пунктээр нэмэгдсэн байна.

Хүснэгт 24. Импортын бүтэц, барааны бүлгээр, дүнд эзлэх хувь

Бүлэг	2016	2017	2018	2019*
Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	9.8	8.7	7.4	7.3
Эрдэс бүтээгдэхүүн	21.6	22.8	22.6	22.4
Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	6.3	7.7	9.2	8.8
Машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл эд анги, дуу хураагч, телевизор, эдгээрийн сэлбэг	20.3	21.2	21.9	20.2
Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги	13.0	14.4	15.3	19.0
Бусад	29.1	25.2	23.7	22.3
Нийт дүн	100	100	100	100

Импортын хэмжээ 2019 онд 6.1 тэрбум америк доллар болж, 2016 оноос 82.5 хувиар өссөн байна. Импортын дүнд эрдэс бүтээгдэхүүн машин, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн импорт зонхилох хандлага хэвээр байна.

Хүснэгт 25. Инфляцын түвшин, 2016-2019 оноор, хэрэглээний бараа, үйлчилгээний бүлгээр, хувиар

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2019	<u>2019</u> 2016
Ерөнхий индекс	100	5.2	22.0
Согтууруулах ундаа, тамхи	4.4	2.7	17.2
Хувцас, бөс бараа, гутал	16.6	22.3	22.4
Орон сууц, ус, цахилгаан, түлш	9.3	6.3	32.8
Гэр ахуйн тавилга, бараа	4.9	3.7	18.5
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	2.5	30.4
Тээвэр	14.4	-4.0	17.3
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	0.0	-1.4
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.1	5.5	27.8
Боловсролын үйлчилгээ	4.8	9.9	42.2
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	3.0	5.4	21.1
Бусад бараа, үйлчилгээ	5.4	6.0	22.6

Инфляц 2012-2015 онд жилд дунджаар 9.9 хувиар нэмэгдэж байсан бол 2016-2019 онд дунджаар 5.3 хувиар нэмэгдсэн нь өмнөх 4 жилийн дунджаас 4.6 пунктээр буурсан байна. Өмнөх жилүүдтэй адил өрхийн зарлагад өндөр хувийн жин эзэлдэг цөөн нэрийн хүнсний барааны үнийн өсөлт инфляцад нөлөөлсөн хэвээр байна.

Хүснэгт 26. Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт, жил бүрийн эцэст

Мөнгөний зарим үзүүлэлт		2016	2017	2018	2019
		тэрбум төгрөг			
Мөнгө M2		12158.5	15861.2	19474.8	20833.8
	Бага мөнгө M1	2 147.7	2 826.0	4 031.0	3 904.2
	Төгрөгийн харилцах	1 584.8	2 214.3	3 360.5	3 289.7
	Хадгаламжийн байгууллагаас гадуурхи мөнгө	562.9	611.7	670.5	614.5
	Бараг мөнгө	10010.8	13035.2	15443.8	16929.6
	Төгрөгийн хадгаламж	5 789.9	8 622.0	10156.3	11119.7
	Валютын хадгаламж	2 789.7	2 531.9	3 019.5	3 483.7
	Валютын харилцах	1 431.2	1 881.3	2 268.0	2 326.2
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө		823.6	906.4	968.6	897.4

Эдийн засаг тэлэхийн хэрээр мөнгөний нийлүүлэлт нэмэгдэж, 2019 оны эцэст 20.8 их наяд төгрөгт хүрчээ. Төгрөгийн хадгаламж 2016 онтой харьцуулахад өсөж, харин валютын хадгаламж буурсан байна. Мөнгөний нийлүүлэлтийн дийлэнх хувийг иргэд, байгууллагын хадгаламжийн өсөлтөөр хангасан хэвээр байна.

Хүснэгт 27. Монголбанкнаас зарласан төгрөгийн гадаад валюттай харьцах жилийн дундаж ханш, төгрөгөөр

Гадаад валют	2016	2017	2018	2019
Гадаад валютын ханш, жилийн дундаж				
АНУ-ын доллар	2147.74	2440.63	2472.67	2663.94
Евро	2181.67	2757.59	2918.78	2982.14
Рубль	32.17	41.88	39.49	41.20
Юань	313.12	361.33	373.88	385.56
Вон	1.74	2.16	2.25	2.28
Иен	16.34	21.76	22.39	24.45
Фунт	3009.65	3145.04	3298.44	3400.25
Гадаад валютын ханш, жилийн эцэст				
АНУ-ын доллар	2489.53	2427.13	2463.69	2734.33
Евро	2605.79	2897.87	3024.65	3063.54
Рубль	41.03	42.12	37.97	44.06
Юань	357.96	371.58	384.34	392.39
Вон	2.06	2.27	2.37	2.37
Иен	21.19	21.53	23.98	25.17
Фунт	3057.89	3264.73	3364.89	3590.31


Гадаад валютын улсын нийт албан нөөцийн дүн 2019 оны эцэст 4.3 тэрбум ам.доллар болж, 2016 оноос 3.3 дахин өссөн байна.

Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартой харьцах жилийн дундаж ханш 2019 онд 2663.94 төгрөг болж, 2016 оноос 24.0 хувиар, төгрөгийн юаньтай харьцах жилийн дундаж ханш 385.56 төгрөг болж, 23.1 хувиар, төгрөгийн рубльтэй харьцах жилийн дундаж ханш 41.20 төгрөг болж, 28.1 хувиар тус тус суларсан байна.


СТАТИСТИКИЙН БИЗНЕС РЕГИСТРИЙН САНД бүртгэлтэй ААНБ-ын тоо үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар



ИНФЛЯЦЫН ТҮВШИН, 2016-2019 оноор, хувиар



ТӨРИЙН САНХҮҮ



Хүснэгт 28. Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого, оны үнээр, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2012- 2015 оны дундаж	2016- 2019 оны дундаж	2016-2019 2012-2015
Нийт орлого, тусламжийн хэмжээ	5 811.2	8 961.4	154.2
Ирээдүйн өв сан	-	672.9	-
Тогтворжуулалтын сан	45.9	209.1	4.6 ¹
Нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн хэмжээ	5765.2	8 299.8	144.
Татварын орлого	4 888.0	7 328.2	149.9
Орлогын албан татвар	1063.1	1 817.	170.9
Нийгмийн даатгалын орлого	865.1	1 534.7	177.4
Хөрөнгийн албан татвар	57.7	132.9	2.3 ¹
Нэмэгдсэн өртгийн албан татвар	1288.2	1 860.6	144.4
Онцгой албан татвар	452.1	691.1	152.9
Тусгай зориулалтын орлого	17.7	13.1	74.2
Гадаад үйл ажиллагааны орлого	346.2	578.4	167.1
Бусад татвар, төлбөр, хураамж	786.1	700.5	89.1
Татварын бус орлого	882.3	971.6	110.1
Нийтлэг татварын бус орлого	837.8	909.4	108.5
Хөрөнгийн орлого	25.0	0.9	3.4
Тусламжийн орлого	19.5	61.3	3.1 ¹

Улсын нэгдсэн төсөвт 2012-2015 онд жилд дунджаар 5.8 их наяд төгрөгийн орлого төвлөрүүлж байсан бол 2016-2019 онд 9.0 их наяд төгрөг болж, 54.2 хувиар өссөн байна. Харин энэ хугацаанд төсвийн нийт зарлага, цэвэр зээлийн хэмжээ 6.6 их наяд төгрөгөөс 9.8 их наяд төгрөг болж 48.2 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 29. Монгол Улсын нэгдсэн төсвийн зарлага, цэвэр зээл, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2012-2015 оны дундаж	2016-2019 оны дундаж	2016-2019 2012-2015
Нийт зарлага, цэвэр зээлийн хэмжээ	6 616.3	9 808.6	148.2
Нийт зарлага	6 544.1	9 436.6	144.2
Урсгал зардал	5 136.1	7 339.4	142.9
Бараа, ажил үйлчилгээний зардал	2 612.4	3 402.8	130.3
Хүү	406.9	1 013.0	2.5 ¹
Татаас, урсгал шилжүүлэг	2 116.7	2 923.6	138.1
Хөрөнгийн зардал	1 546.0	2 111.1	136.6
Дотоод эх үүсвэрээр	1 396.5	2 097.2	150.2
Гадаад эх үүсвэрээр	149.4	0.0	0.0
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	72.2	372.	5.2 ¹

Нэгдсэн төсвийн нийт зарлагын бүтцийг авч үзвэл, 2016-2019 онд жилд дунджаар 2012-2015 оноос урсгал зардал 2.8 пункт, бараа, ажил, үйлчилгээний зардал 4.8 пункт, татаас, урсгал шилжүүлэг 2.2 пункт, хөрөнгийн зардал 1.8 пунктээр тус тус буурсан бол хүүгийн зардал 4.2 пункт, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 2.7 пунктээр өссөн байна.

Улсын нэгдсэн төсөв 2018 онд 3.0 тэрбум төгрөгийн ашигтай, 2016, 2017, 2019 онд 3660.8-627.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

Хүснэгт 30. Монгол Улсын нийт гадаад өр, салбараар, сая ам.доллар

Үзүүлэлтүүд	2016	2017	2018	2019
Нийт гадаад өр	24 624.5	27 492.7	28 714.9	30 677.8
Засгийн газар ¹ , зах зээлийн үнэлгээ	4 868.6	7 321.0	7 184.2	7 701.7
Төв банк	1 790.8	2 025.1	2 030.2	1 984.7
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	2 417.4	2 194.3	2 230.4	2 140.1
Бусад салбарууд	8 121.5	7 955.8	8 041.9	8 517.4
Шууд хөрөнгө оруулалт: Компани хоорондын зээллэг	7 426.3	7 996.5	9 228.2	10 333.9

Монгол Улсын нийт гадаад өр 2019 оны жилийн эцэст 30.7 тэрбум ам.доллар болж, 2016 оноос 6.1 тэрбум ам.доллар буюу 24.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 31. Засгийн газрын нийт өр, тэрбум төгрөг

Үзүүлэлтүүд	2016	2017	2018	2019
Засгийн газрын нийт өр	22 280.1	22 751.6	22 367.0	23 915.1
Засгийн газрын дотоод өр, өрийн хэрэгслээр	5 796.0	3 461.9	1 564.7	1 399.6
Үнэт цаас	5 488.8	3 461.9	1 564.7	1 399.6
Засгийн газрын гадаад өр ¹ , өрийн хэрэгслээр	12 363.8	16 857.8	18 865.6	20 443.5
Үнэт цаас	5 380.5	7 701.6	7 664.5	7 927.2
Зээл	6 983.3	9 156.2	11 201.1	12 516.3
Засгийн газрын өрийн баталгаа	3 451.5	1 663.7	1 130.7	1 076.3
Барих- Шилжүүлэх төрлийн концесс	668.9	768.2	806.0	995.7

Засгийн газрын нийт өр 2019 оны эцэст 23.9 их наяд төгрөг болж, 2016 оноос 1.6 их наяд төгрөг буюу 7.3 хувиар нэмэгдсэн байна. Засгийн газрын өрийн бүтцэд 2015 онд гадаад өр 54.6 хувийг эзэлж байсан бол 2019 онд 85.5 хувь болж, 30.9 пунктээр нэмэгдсэн байна. Засгийн газрын нийт өрөөс 2019 онд үндсэн төлбөрт 603.4 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 894.5 тэрбум төгрөг төлөгдсөн байна. Үндсэн төлбөрийн төлөлт 2019 онд 2015 оноос 1.7 их наяд төгрөг буюу 73.8 хувиар буурч, хүүгийн төлбөр 329.8 тэрбум төгрөг буюу 58.4 хувиар өсжээ.

Дэлгэрэнгүй тайлантай танилцахыг хүсвэл дараах QR-ийг уншуулна уу.

